



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 09 сарын 03 өдөр

Дугаар 318

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын ээлжит бус
чуулган товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.2, 18.4 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг 2026 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс 09 дүгээр сарын 14-ний өдрүүдэд хуралдуулахаар зарлаж, дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай:


1/Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

2/Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

2. Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдааныг 2026 оны 09 дүгээр сарын 07-ны Даваа гарагийн 10:00 цагт эхлэхээр товлосугай.

3. Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Байнгын хороодын дарга нар болон Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга (Л.Өлзийсайхан)-д даалгасугай.

ДАРГА



С.БЯМБАЦОГТ

2026000996